



2026 оны 8 дугаар сарын 12-ны өдөр

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.51 дэх заалтад “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв гэж Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Эрүүл мэндийн салбарт 2021 оны төсвийн жилээс эхлэн төрөөс зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлж, нэг худалдан авагчийн тогтолцоог бий болгосноор тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, иргэдийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлого тодорхой түвшинд биеллээ олсон.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн төслийг эмнэл зүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг стратегийн худалдан авалтын зарчимд үндэслэн батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх, даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс

хамгаалах бодлогыг үргэлжлүүлэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд нийцүүлэн боловсруулах шаардлагатай байна.

Мөн эрүүл мэндийн салбарт эмч, эмнэлгийн ажилтнуудын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх, тусламж, үйлчилгээний тасралтгүй, хэвийн байдлыг хангах шаардлагын хүрээнд тус салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлнэ. Тиймээс төрийн албан хаагчдын цалин хөлс болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын дундаж цалин хөлсний өөрчлөлттэй уялдуулан эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Энэ хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бүс нутгийн онцлог байдал, тусламж, үйлчилгээний төвлөрөл сааруулах бодлоготой уялдуулан олгох, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд илүүтэйгээр чиглүүлнэ. Түүнчлэн эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн өсөлтийг харгалзан эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлага бий болж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Эрүүл мэндийн даатгалын санд 2027 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, зарцуулах төсвийн эрх, хэмжээ, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт төсвийн ерөнхийлөн захирагчийн эргэн төлөх төлбөрийн тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу 2027 оны төсвийн жилд эрүүл мэндийн даатгалын сан бие даасан хэлбэрээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалаас үзүүлэх тусламж,

үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---